



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.08.05 № 011759
танай 2024.06.26 -ны № 24/45 -т

ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР
НАМЫН ДАРГА О.ЗАЯА ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох "Хөгжлийн хөтөлбөр" намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

"Хөгжлийн хөтөлбөр" намын Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Хөгжлийн хөтөлбөр" намын мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Төв аймгийн Сонгуулийн хороонд

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

019021071



ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР НАМ

**ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР
НАМ**

**“ХӨГЖИНГҮЙ МОНГОЛ
ХӨГЖЛИЙН ШИНЭ ГАРЦ”
ХӨТӨЛБӨР
/2024-2028/**

(Хөгжлийн хөтөлбөр намын 2024 оны аймаг нийслэл сум дүүргийн иргэдийн төдөөдөгчидийн хурлын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр)



Улаанбаатар хот
2024он

ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР НАМЫН ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧ АГУУЛГА

- ❖ Ард түмнээ дээдэлсэн "Хүн төвтэй", ардчилсан иргэний нийгмийг төлөвшүүлж, хариуцлага, ёс суртахуунтай шударга төрийн залгамж чанарыг үргэлжлүүлнэ.
- ❖ Эдийн засгийн тогтвортой нөхцлийг хангаж, дотоодын нөөц баялагт түшиглэсэн үйлдвэржсэн орон болно.
- ❖ Төрийн санхүүгийн сахилга батыг сайжруулж, ил тод байдлыг ханга
- ❖ Эрчим хүчний үнэ тарифийг бууруулах оновчтой саналыг дэмжин хөгжүүлж үнийн хөөрөгдлийг зогсооно.
- ❖ Цөлжилтийг сааруулж, ногоон хөгжлийг дэмжин, эрүүл ая тухтай, орчныг бүрдүүлнэ.
- ❖ Бизнесийн орчинг эрүүлжүүлж зөв хөгжилд оруулна.
- ❖ Айх аюулгүй, амар түвшин, сэтгэл хангалуун амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.




НИЙГЭМ



ЭДИЙН ЗАСАГ



БАЙГАЛЬ ОРЧИН



Улсын төсвийн бодлогын зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх аргууд

Зорилт 1.

Судалгаанд суурилсан хөгжлийн стратеги бодлого, Засгийн газрын санхүүгийн дунд болон урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санхүүгийн төлөвлөлтийг чиглүүлнэ.

Хэрэгжүүлэх аргууд:


- Үндсэн чиглэл, төсөв, мөнгөний бодлогын уялдаа холбоог өнөөгийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэх;
- Улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтийн уялдаа холбоог хангах;
- Орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн эрх хэмжээг нэмэгдүүлж, хариуцлагын тогтолцоог сайжруулах;
- Төсвийн байгууллагуудын төсвийг бодит хэрэгцээнд нь нийцүүлэн төлөвлөж санхүүжүүлэх;
- Санхүүгийн дунд болон урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийг оновчтой болгох;
- Санхүүгийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх.

Зорилт II.

Төсвийн хөрөнгө оруулалтыг судалгаанд суурилсан хөгжлийн стратеги бодлоготой уялдуулан тогтвортой нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх аргууд:

- Судалгаанд суурилсан хөгжлийн бодлогын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд төсвийн бодлогыг чиглүүлэх;
- төслүүдэд тулгуурлан улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх
- Төсвийн хөрөнгө оруулалтыг хүнд өгөөжтэй эдийн засгийн өсөлтийг дэмжиж, эдийн засгийн оновчтой бүтцийг бүрдүүлэхэд чиглүүлэх;
- Бүсүүдийн хөгжлийг хурдасгах төслүүдийг төсвийн хөрөнгө оруулалтаар дэмжинэ.



Зорилт III.

Хүн амын дунд өрнөсөн сайн санаачлагуудыг бодлогоор дэмжих

Хэрэгжүүлэх аргууд

- Ажлын байр шинээр бий болгоход чиглэсэн бодлогыг дэмжих

Зорилт IV.

Стратегийн орд газруудаас олсон ашгаас "Хөгжлийн сан" бүрдүүлэх замаар зохистой ашиглана.

Хэрэгжүүлэх аргууд:

- "Хөгжлийн сан", "Эрсдлийн сан" болон бусад сангуудыг бүрдүүлж нийгэм эдийн засгийн хөгжлийг хурдасгах, макро эдийн засгийн тогтворжилтыг хангахад ашиглах.

Өрсөлдөх чадварыг сайжруулах зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх аргууд

Зорилт I.

Хүнээ хөгжүүлж, мэдлэг чадварыг нь дээшлүүлэхэд чиглэсэн санхүүгийн оновчтой бодлого явуулна.

Хэрэгжүүлэх аргууд:


- Гадаадын оюунжсан өндөр технологид нэвтрэх боломжийг санхүүгийн бодлогоор дэмжих;

Зорилт II.

Үйлдвэрлэл, үйлчилгээнд өндөр технологийг нэвтрүүлж өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн санхүүгийн бодлого явуулна.

Хэрэгжүүлэх аргууд:

- Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах санхүүгийн хууль, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх;



- Эдийн засгийн чөлөөт бүсүүдийг хөгжүүлж өндөр технологи нутагшуулахад чиглэсэн санхүүгийн бодлого явуулах.

1.1. Эрчим хүчний салбарын санхүүгийн бодлогын зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх аргууд

Зорилт 1. Монгол улсын эрчим хүчний нэгдсэн системийг байгуулж, эрчим хүчний салбарын ашигт ажиллагааны түвшинг дээшлүүлэн, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн санхүүгийн бодлого явуулна.

Хэрэгжүүлэх аргууд:


- Говийн бүсийн цахилгаан хангамжийн бодлогыг тодорхойлж ойрын жилүүдэд бий болох Оюутолгой, Цагаансуварга болон бусад уул уурхайн үйлдвэрүүдийн эрчим хүчний хангамжийн эх үүсвэрийг бий болгох ажлыг санхүүгийн бодлогоор дэмжих;
- Эрчим хүчний салбарт орчин үеийн технологи тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулахад чиглэсэн санхүүгийн бодлого явуулах.

Зорилт 2.

Монгол улсын эрчим хүчний нэгдсэн системийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн санхүүгийн бодлого явуулна.

Хэрэгжүүлэх аргууд:

- Улаанбаатар хотын эрчим хүчний хангамжийг сайжруулах асуудлыг санхүүгийн бодлогоор дэмжих;
- Бүс нутгуудын эрчим хүчний системийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн санхүүгийн бодлого явуулах.




1.2. Түлшний салбарын санхүүгийн бодлогын зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх аргууд

Зорилт 1. Нүүрсний хийн болон ус агаарыг ашиглан бага оврын цахилгаан станцуудыг байгуулж, хөдөө орон нутгийн эрчим хүчний хангамжийг сайжруулахад чиглэсэн санхүүгийн бодлого явуулна.

Хэрэгжүүлэх аргууд:

- Нүүрсний ордуудад ойрхон байрлалтай сум, суурин газарт нүүрсний хийн түлшээр ажилладаг бага оврын цахилгаан станц барьж ажиллуулахад чиглэсэн санхүүгийн бодлого явуулах;
- Нүүрснээс утаагүй түлш үйлдвэрлэдэг бага оврын үйлдвэрүүдийг байгуулахад чиглэсэн санхүүгийн бодлого явуулах;
- Таван толгойн коксжих нүүрсний ордыг ашиглаж эхлэнэ.
- Нүүрс боловсруулах, хийжүүлэх, шингэрүүлэх тоног төхөөрөмж бүхий нүүрс-химийн судалгааны лаборатори, төв байгуулж ажиллуулахыг санхүүгийн бодлогоор дэмжих;

Нүүрснээс газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэж, импортыг бууруулахад чиглэсэн санхүүгийн бодлогоор дэмжи



**Хөгжлийн хөтөлбөр намын
2024-2028 оны сонгуулийн
мөрийн хөтөлбөр**

Алсан хараа

Улс орны тусгаар тогтнол, эв нэгдлийг бататган "Хүнээ дээдэлсэн" хүн төвтэй төрийн тогтолцоог буй болгож, шударга, ардчилсан, аз жаргалтай, эрүүл нийгмийг төлөвшүүлж улс орноо хөгжүүлнэ.


**1. Улс төрийн зорилт, хөтөлбөр
Зорилтын агуулга:**

Монгол улсын эрхэм дээд баялаг бол Монгол хүн мөн. Монгол хүн төрийн хамгаалалтад байж хөгжлийн бодлогыг зорилго бүр Монгол хүний сайн сайхан байдлыг дээшлүүлж эрүүл байлган урт наслуулахад чиглэх болно.

Ардын уламжлалт ахуй соёл, сэтгэхүй, оюун санааны өвийг дээдлэн хөгжүүлж иргэн бүр ажил, сургууль, орлоготой байж ядуу иргэнгүй, нийгмийн чинээлэг дундаж давхарагатай, эдийн засгийн эрх чөлөө, хувийн хэвшил, өмчийн халдашгүй дархан байх эрхийг хуулиар чанд сахин хамгаалсан иргэний ардчилсан шударга төр нь улс орон, ард түмнийхээ эрх ашгийг дээдэлсэн Монгол орны оршин тогтнох, хөгжин цэцэглэх, сэрэн мандахыг үндэс болно.

1.1 Улс төрийн намууд төрд ноёрхох, ард иргэдээ намын харъяалал, нутаг ус, итгэл үнэмшил, сүсэг бишрэл, өмч хөрөнгөөр нь алагчлан зааглаж, хуваан өмчлөх үзэгдлийг эцэс болгож, нийгмийн талцал, хуваагдлын үндэс болсон улс төрийн намын хатуу гишүүнчлэлгүй бодлогын улс төрийн хүчинболгох.

1.2 Улс төрийн намууд төрийн өндөр албан тушаалд дэвшүүлж сонгосон, томилуулсан хүнийхээ төлөө хүлээх хариуцлагыг чангатгаж, төрийн албан хаагчид хээл хахууль



авилгалын хэрэг үйлдсэн тохиолдолд хүлээх ял шийтгэлийг хүндрүүлж, төрийн албанд ажиллах эрхийг нь хязгаарлах.

1.3 Ард иргэдийг талцалд хүргэсэн нийгмийн амьдралын гол зангилаа асуудлууд түүний дотор Үндсэн хуулиар бүх ард түмний мэдэлд байхаар заасан асуудлыг ард түмний санал асуулгаар шийдэх ёсыг хэрэгжүүлж дэвшүүлэх

1.4 Нүүдлийн соёл иргэншлийн үндсийн үндэс болсон малчин, мал, бэлчээрийн газар нутгийн дархлааг хангасан хууль эрх зүйн тогтвортой орчинг бий болгох


2. Эдийн засгийн хөгжлийн зорилт, хөтөлбөр

Үндэснийхээ эдийн засгийн тусгаар тогтнолыг тууштай сахин бэхжүүлж, өргөн уудам нутаг дэвсгэр, эрчим хүч, түүхий эдийн нөөцөө түшиглэн инновацийн хүч, орчин үеийн тэргүүний техник технологийг ашиглаж өндөр үр ашигтай, тогтвортой, өөрийн хуримтлалаар өсөж хөгжих, өөрийгөө нөхөн тэтгэх, гадаад орчны өөрчлөлтөнд дасан зохицох чавдартай макро түвшний эдийн засгийн нэгдсэн орон зайг бий болгохыг зорино.

2.1 Төрийн бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөж, шинжлэн судлаж хэрэгжүүлдэг байх. Үүний тулд улс орны хөгжлийг төлөвлөх чадавхитай бодлого төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх. Үндэсний эдийн засгийн бодлого, хэтийн төлөвийг тодорхойлох, төсөөлөхдөө дараахь зарчмуудыг баримтлах

- Хүний хөгжил
- Эв зохицолтой хөгжил
- Тэнцвэртэй хөгжил
- Ногоон хөгжил
- Хуримтлалтай хөгжил
- Хөрш орнуудтай хорших хөгжил


2.2 Эдийн засгийн эрх зүйн орчинг бүхэл цогцоор дараахь шаардлагуудад нийцүүлэн төгөлдөржүүлэн хэрэгжүүлэх, бүтцийг шинэчлэх,



- Эдийн засгийн уналтыг зогсоох, тогтворжуулах, өсөлтийг хангах цогц бодлого хэрэгжүүлэх.
- Олон улсын стандартад нийцсэн өндөр хөгжил бүхий банк, санхүү, даатгал, хөрөнгө оруулалтын сан, хөрөнгийн зах зээлийн үйлчилгээний тогтолцоог эрчимтэй хөгжүүлж хууль эрх зүйн орчинг нь улам нээлттэй, ил тод хяналт зохицуулалттай болгох;
- Эдийн засгийн чөлөөт бүсийг жинхэнэ утгаар нь бүрдүүлж газар нутгийг нь тэлж, эдийн засгийн чөлөөт бүсийн хуулийг сонгодог утгаар гаргаж хэрэгжүүлэх;
- Үндэсний эдийн засгийн тусгаар тогтнол, аюулгүй байдал, тогтвортой байдлыг хэрэгжүүлэх, Төрийн бодлогын нэгдмэл байдлыг хангаж, эдийн засгийг улс төрийн нам, фракц, нам дамнасан бүлэглэлийн "улс төрийн барьцаа"-наас салгах
- Төр, хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагааны тогтвортой орчинг бүрдүүлэх;
- Гадаадын хөрөнгө оруулагчдад тавих шаардлага, хамтарч ажиллах гэрээ хэлэцээрүүдэд үндсэн хууль бусад хуулийг чанд мөрдөж улс орныхоо эрх ашгийг тууштай хамгаалах чадавхи бүрдүүлэх;

2.3 Үндэсний эдийн засгийн бүтцийг нягтаруулж, түлш, шатахуун, эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, нүүрс-хими, нефть-хими, өнгөт болон хар төмөрлөг, тенхик тоног төхөөрөмжийн салбарт өндөр технологи бүхий бага, дунд оврын үйлдвэрүүдээр эх орны түүхий эдийг боловсруулахыг дэмжсэн бодлого явуулах;

- Эрчим хүч импортлогч орноос экспортлогч орон болох;
- Орон нутагт сум дундын хэрэглээг хангахуйц бага дунд оврын усан цахилгаан станц барих бодлогыг дэмжиж хэрэгжүүлэх;



- Олборлолт - Экспортын чиг хандлагатай уул уурхайн салбарыг Олборлолт - Боловсруулалт - Экспортын чиг хандлагатай болгон өөрчлөх;
- Эх орныхоо эрдэс түүхий эдийн баялагыг ариг гамтай, байгаль экологид хор хөнөөл учруулахгүйгээр олборлож, хамгийн үр ашигтай, хөрөнгө оруулалттаа богино хугацаанд нөхөж, үр өгөөжөө өгөх технологийн шатанд хүртэл боловсруулж, дотоод хэрэгцээгээ бүрэн хангаж, экспортын тогтвортой нөөц, эх үүсвэр бүрдүүлэх;


2.4 Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлээр ард иргэдийнхээ хүнсний хэрэгцээг генийн өөрчлөлтгүй, экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, экспортлох хэмжээнд хүртэл тэтгэн хөгжүүлж, малчид, тариаланчдыг үнийн хэт алдагдалтай өөрчлөлт, зээлийн өрийн дарамтаас хамгаалах бодлого хэрэгжүүлэнэ.

3. Нийгмийн хөгжлийн зорилт хөтөлбөр

3.1 "Хүн" төвтэй нийгмийн хөгжлийн бодлого баримталж, иргэдийнхээ амьдралын аюулгүй байдлын баталгааг бэхжүүлж, хүнээ хөгжүүлж, амьдралын баталгааг сайжруулж ядуурлыг бууруулж нийгмийн дундаж давхаргыг тэлэх

3.2 Боловсролын салбарын бүх шатны сургалтын хөтөлбөрийг орчин цагийн шинжлэх ухааны боловсрол олгох шаардлагад нийцүүлэн сайжруулж Монгол бичиг, кирилл бичиг эзэмших "Хос бичигтэн", гадаад хэл эзэмших "Хос хэлтэн" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

- Хүүхэд, залуучуудын эх хэлний мэдлэгийг сайжруулах бодлогыг баримтлах
- 2025 оноос Монгол бичгийг төрийн албаны ёсны бичиг болгох;
- Үндэсний их дээд сургуулиудын сургалтын стандартыг олон улсын хүлээн зөвшөөрөх түвшинд тогтоох, сургалт, сорилт-туршилтын лаборатори судалгаа шинжилгээний баазтай байх шаардлагыг үндэсний стандарт болгон мөрдүүлэх;



- Мэргэжилтэй ажилчин бэлтгэн ажлын байраар хангах бодлогыг баримтлах

3.3 Эмнэлгийн үйлчилгээг цогцоор хөгжүүлж юуны өмнө, түгээмэл тархаж, иргэдийн эрүүл мэнд амь насанд ноцтой аюул учруулж буй өвчнийг дэлхийн түвшинд оношлох, эмчлэх үндэсний төвүүдийг төрөлжүүлэн бэхжүүлж, дэмжих;

3.4 Монгол соёл иргэншлийн дэвшилтэт ололт, үнэт зүйлсийг уламжлал шинэчлэлийн ухаалаг зөв харьцаанд хадгалан, хамгаалах хөгжүүлэх замаар дэлхийн соёл урлагт үндэснийхээ соёлын эзлэх байр суурийг бэхжүүлэн, Монгол хэл, соёл мөхөж доройтох, өөр үндэсний хэл, соёлд уусан замхарах, өв уламжлал, ёс заншил алдагдах, оюун санааны амьдрал ядууран доройтохоос сэрэмжлэхэд соёл урлагийн бодлогын зорилт чиглэгдэнэ.


- Үндэсний язгуур урлаг, уртын дуу, сонгодог урлагийн үндсэн төрлүүд болох. Сонгодог хөгжим, бүжгэн жүжиг, дуурь, уран зураг, баримлын урлагийг төрөөс дэмжиж ивээлдээ авах

3.5 Их спорт, нийтийн биеийн тамирыг харилцан уялдаатай хөгжүүлж, Олимпийн наадамд тамирчидаа бэлтгэх асуудал төрийн анхааралд байлгах

4. Байгаль орчин хамгаалах зорилт, хөтөлбөр

Үндсэн бодлого чиглэл:

- ✓ Байгалийн нөөцийг үр өгөөжтэй ашиглан, эко системийн тогтвортой байдлыг хадгалах замаар хүртээмжтэй өсөлтийг бий болгоно.
- ✓ Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлэн ариун цэврийн байгууламжийг төрийн бодлогын салшгүй хэсэг болгоно.




- ✓ Байгаль орчноо хайрлан хамгаалах үзэл сайн туршлагыг хөхүүлэн дэмжих замаар дадал болгоно
- ✓ Байгаль орчноо хамгаалан тэтгэж, хүрээлэн буй орчныг эрүүлжүүлэх бодлогыг шинэ шатанд гаргана
- Говь, талын бүс нутагт ундны усыг аж ахуйн зориулалтаар хэрэглэхийг багасгахад хүчтэй түлхэц өгөх эдийн засаг, эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- Улаанбаатар хот, бусад томоохон хот суурин газруудын цэвэрлэх байгууламж, хог хаягдлыг устгах, боловсруулах технологи, хүчин чадлыг олон улсын шилдэг жишигт хүргэж, хяналтыг тогтмолжуулна.
- Байгаль орчны нөхөн сэргээлт хийгээгүй аж ахуйн нэгжүүдийг хар жагсаалтанд оруулж, уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх эрхийг нь тодорхой хугацаагаар хязгаарлаж, дахин шинээр хайгуулын болоод ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй байна.

5. Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар

Аялал жуулчлалын салбарт үндэсний онцлогт тулгуурласан хөтөлбөрүүдийг боловсруулж олон улсын стандартыг төлөвшүүлэхэд хууль эрх зүйн орчины шинэтгэл хийнэ.

5.1 Байгалийн унаган байдлыг хадгалах замаар тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

5.2 Монгол Улсын төрөөс аялал жуулчлалын талаар баримтлах бодлого үзэл баримтлалд Монгол угсаатны нүүдлийн соёл иргэншлийг шингээсэн 4 улирлын өнгө төрх үзэсгэлэнт түүх соёлын дурсгалт газар, археологийн олдвор, дэлхийд нэн ховордсон биологийн олон төрөл зүйл зэрэг давуу талуудыг зүй зохистой




хослуулсан, гадаад дотоодын жуулчдын эрэлт хэрэгцээ сонирхолд нийцсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх.

5.3 Гадаад дотоодын аялал жуулчлалыг нутгийн иргэдийн шууд оролцоонд тулгуурласан экологийн баримжаатай үзэл баримтлалыг Монгол улсын төрөөс аялал жуулчлалын талаар баримтлах бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлнэ.

Аюулгүй байдал, гадаад харилцааны зорилт, хөтөлбөр

Монгол Улсын гадаад бодлогын энхтайван, эв найрамдал, түншлэлийг эрхэмлэсэн уламжлалыг улам гүнзгийрүүлэн хөгжүүлнэ:


- Гадаад орнуудтай түншлэн хамтран ажиллах бүх хүрээнд үндэснийхээ эрх ашгийг найдвартай хамгаалан ул суурьтай хандах зарчмыг тууштай баримталж, харилцан тохиролцсон хүрээндээ найдвартай, хариуцлагатай түнш байх баталгаа бүрдүүлэх эрх зүй, зохион байгуулалтын нөхцөл бий болгоно.
- Хил залгаа хоёр хөрш оронтой харилцаа, хамтын ажиллагаагаа цаашид өргөтгөн хөгжүүлэхэд онцгой ач холбогдол өгч, хөрш тус бүртэйгээ харилцан ашигтай, тэгш хэмтэй, тэнцвэртэй, хөгжил дэвшилд чиглэсэн тогтвортой худалдаа, хамтын ажиллагаа эрхлэх чиглэл баримтална.
- Гадаадын хөрөнгө оруулагчидтай гэрээ хэлцэл хийхдээ Монгол Улсын тухайн үеийн хууль тогтоомжийг зөрчсөн бүх үйлдлүүдийг нэн анхааралтай шинжлэн үнэлж, улс үндэснийхээ эрх ашгийг хохироосон актуудыг хүчингүй болгох буюу өөрчлөх, Монголын талаас ийм үйлдэл хийсэн хүмүүст хуулийн хариуцлага хүлээлгэх .
- Улс орныхоо гадаад, дотоод орчин нөхцлийг бодитой үнэлж, даяаршлын үед үндэснийхээ язгуур эрх ашгийг баталгаажуулан хамгаалахад чиглэсэн батлан хамгаалах бодлогоо хадгалан уламжлуулна.



- Насанд хүрсэн бүх эрэгтэйчүүд, цэргийн боловсрол олж, 18-45 насны эрчүүд 5 жил тутам улирлын цугларалтаар бэлтгэлээ сэргээх тогтолцоотой болох
- Хилийн хамгаалалтыг мэргэжлийн цэрэг болон нутгийн иргэдийн хамтын ажиллагаанд тулгуурлан бататгах;
- Олон улсын энхийг сахиулах хүчний үйл ажиллагаанд оролцох мэргэшсэн цэрэг, офицеруудыг бэлтгэх тогтолцоог цаашид боловсронгуй болгон хөгжүүлэх;

**МОНГОЛ УЛС ЦЭЦЭГЛЭН ХӨГЖИЖ, МОНГОЛ ХҮН БҮР ЭРҮҮЛ ЭНХ, ЭРДЭМ
БОЛОВСРОЛТОЙ, АЗ ЖАРГАЛТАЙ АМЬДРАХ БОЛТУГАЙ.**

---oo00oo---

A handwritten signature in black ink, consisting of several loops and a long horizontal stroke extending to the right.



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024-08-05 № 01/760

танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох "Хөгжлийн хөтөлбөр" намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

"Хөгжлийн хөтөлбөр" намын Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Хөгжлийн хөтөлбөр" намын мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: "Хөгжлийн хөтөлбөр" намд

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

019021076



**ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР
НАМ**

**“ХӨГЖИНГҮЙ МОНГОЛ
ХӨГЖЛИЙН ШИНЭ ГАРЦ”
ХӨТӨЛБӨР
/2024-2028/**

(Хөгжлийн хөтөлбөр намын 2024 онд аймаг, нийслэл, сум, дүүргийн
Иргэдийн төлөөлөгчийн сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр)



Улаанбаатар хот
2024он

ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР НАМЫН ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧ АГУУЛГА

- ❖ Ард түмнээ дээдэлсэн "Хүн төвтэй", ардчилсан иргэний нийгмийг төлөвшүүлж, хариуцлага, ёс суртахуунтай шударга төрийн залгамж чанарыг үргэлжлүүлнэ.
- ❖ Эдийн засгийн тогтвортой нөхцлийг хангаж, дотоодын нөөц баялагт түшиглэсэн үйлдвэржсэн орон болно.
- ❖ Төрийн санхүүгийн сахилга батыг сайжруулж, ил тод байдлыг хангана.
- ❖ Эрүүл, ажил, орлоготой дундаж давхаргыг буй болгоно.
- ❖ Эрчим хүчний үнэ тарифийг бууруулах оновчтой саналыг дэмжин хөгжүүлж үнийн хөөрөгдлийг зогсооно.
- ❖ Цөлжилтийг сааруулж, ногоон хөгжлийг дэмжин, эрүүл ая тухтай, орчныг бүрдүүлнэ.
- ❖ Хүн ардынхаа эрүүл мэнд, боловсролыг дээшлүүлж, бодит орлогыг нэмэгдүүлэн хүний хөгжлийн индексийг бодитоор үнэлнэ.
- ❖ Бизнесийн орчинг эрүүлжүүлж зөв хөгжилд оруулна.
- ❖ Айх аюулгүй, амар түвшин, сэтгэл хангалуун амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.



НИЙГЭМ



ЭДИЙН ЗАСАГ



БАЙГАЛЬ ОРЧИН

A handwritten signature in black ink, consisting of several loops and a long horizontal stroke.

Улсын төсвийн бодлогын зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх аргууд

Зорилт 1. Судалгаанд суурилсан хөгжлийн стратеги бодлого, Засгийн газрын санхүүгийн дунд болон урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санхүүгийн төлөвлөлтийг чиглүүлнэ.

Хэрэгжүүлэх аргууд:

- Үндсэн чиглэл, төсөв, мөнгөний бодлогын уялдаа холбоог өнөөгийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэх;
- Улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтийн уялдаа холбоог хангах;
- Орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн эрх хэмжээг нэмэгдүүлж, хариуцлагын тогтолцоог сайжруулах;
- Төсвийн байгууллагуудын төсвийг бодит хэрэгцээнд нь нийцүүлэн төлөвлөж санхүүжүүлэх;
- Санхүүгийн дунд болон урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийг оновчтой болгох;
- Санхүүгийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх.

Зорилт II. Төсвийн хөрөнгө оруулалтыг судалгаанд суурилсан хөгжлийн стратеги бодлоготой уялдуулан тогтвортой нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх аргууд:

- Судалгаанд суурилсан хөгжлийн бодлогын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд төсвийн бодлогыг чиглүүлэх;
- төслүүдэд тулгуурлан улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх;
- Төсвийн хөрөнгө оруулалтыг хүнд өгөөжтэй эдийн засгийн өсөлтийг дэмжиж, эдийн засгийн оновчтой бүтцийг бүрдүүлэхэд чиглүүлэх;
- Бүсүүдийн хөгжлийг хурдасгах төслүүдийг төсвийн хөрөнгө оруулалтаар дэмжих;
- Эдийн засгийн чөлөөт бүс, үйлдвэрлэл технологийн паркууд байгуулахад шаардлагатай дэд бүтцийг барьж байгуулахыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дэмжих.

Зорилт III. Хүн амын орлого багатай хэсэгт хандсан төсвийн зарлагын бодлогыг хэрэгжүүлнэ.




Хэрэгжүүлэх аргууд:

- Хүний хөгжлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Ажлын байр шинээр бий болгоход чиглэсэн улсын төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх;
- Тэтгэвэр, тэтгэмжийг үндэсний орлогын өсөлттэй оновчтой уялдуулан нэмэгдүүлэх;
- Гадаадад өндөр мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэхэд төсийн бодлогоор дэмжих.

Зорилт IV.Стратегийн орд газруудыг "Хөгжлийн сан"бүрдүүлэх замаар зохистойашиглана.

Хэрэгжүүлэх аргууд:

- "Хөгжлийн сан", "Эрсдлийн сан" болон бусад сангуудыг бүрдүүлж нийгэм эдийн засгийн хөгжлийг хурдасгах, макро эдийн засгийн тогтворжилтыг хангахад ашиглах.



Өрсөлдөх чадварыг сайжруулах зорилтууд, тэдгээрийгхэрэгжүүлэх аргууд

Зорилт I.Хүнээ хөгжүүлж, мэдлэг чадварыг нь дээшлүүлэхэд чиглэсэн санхүүгийн оновчтой бодлого явуулна.

Хэрэгжүүлэх аргууд:

- Гадаадын оюунжсан өндөр технологид нэвтрэх боломжийг санхүүгийн бодлогоор дэмжих;
- Багш, оюутнуудын англи хэлний мэдлэг, чадварыг дээшлүүлж, шалгалт өгөх сургалт явуулах, хичээлүүдийг англи хэлээр ороход чиглэсэн санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

Зорилт II.Үйлдвэрлэл,үйлчилгээнд өндөр технологийг нэвтрүүлж өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн санхүүгийн бодлого явуулна.

Хэрэгжүүлэх аргууд:

- Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах санхүүгийн хууль, эрх зүйнтаатай орчин бүрдүүлэх;

A handwritten signature in black ink, consisting of several loops and a long horizontal stroke extending to the right.

- Эдийн засгийн чөлөөт бүсүүдийг хөгжүүлж өндөр технологи нутагшуулахад чиглэсэн санхүүгийн бодлого явуулах.

1.1. Эрчим хүчний салбарын санхүүгийн бодлогын зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх аргууд

Зорилт 1. Монгол улсын эрчим хүчний нэгдсэн системийг байгуулж, эрчим хүчний салбарын ашигт ажиллагааны түвшинг дээшлүүлэн, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн санхүүгийн бодлого явуулна.

Хэрэгжүүлэх аргууд:

- Говийн бүсийн цахилгаан хангамжийн бодлогыг тодорхойлж ойрын жилүүдэд бий болох Оюутолгой, Цагаансуварга болон бусад уул уурхайн үйлдвэрүүдийн эрчим хүчний хангамжийн эх үүсвэрийг бий болгох ажлыг санхүүгийн бодлогоор дэмжих;
- Эрчим хүчний салбарт орчин үеийн тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулахад чиглэсэн санхүүгийн бодлого явуулах.

Зорилт 2. Монгол улсын эрчим хүчний нэгдсэн системийн үрашгийг сайжруулахад чиглэсэн санхүүгийн бодлогоявуулна.

Хэрэгжүүлэх аргууд:

- Улаанбаатар хотын эрчим хүчний хангамжийг сайжруулах асуудлыг санхүүгийн бодлогоор дэмжих;
- Бүс нутгуудын эрчим хүчний системийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн санхүүгийн бодлого явуулах.

1.2. Түлшний салбарын санхүүгийн бодлогын зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх аргууд

Зорилт 1. Нүүрсний хийн бага оврын цахилгаан станцуудыг байгуулж, хөдөө орон нутгийн эрчим хүчний хангамжийг сайжруулахад чиглэсэн санхүүгийн бодлого явуулна.

Хэрэгжүүлэх аргууд:



- Нүүрсний ордуудад ойрхон байрлалтай сум, суурин газарт нүүрсний хийн түлшээр ажилладаг бага оврын цахилгаан станц барьж ажиллуулахад чиглэсэн санхүүгийн бодлого явуулах;
- Нүүрснээс утаагүй түлш үйлдвэрлэдэг бага оврын үйлдвэрүүдийг байгуулахад чиглэсэн санхүүгийн бодлого явуулах;
- Тавантолгойн коксжих нүүрсний ордыг ашиглаж эхлэнэ.
- Нүүрс боловсруулах, хийжүүлэх, шингэрүүлэх тоног төхөөрөмжбүхий нүүрс-химийн судалгааны лаборатори, төв байгуулж ажиллуулахыг санхүүгийн бодлогоор дэмжих;

Нүүрснээс газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэж, импортыг бууруулахад чиглэсэн санхүүгийн бодлогоор дэмжих.



A handwritten signature in black ink, consisting of a series of loops and a long horizontal stroke extending to the right.

**Хөгжлийн хөтөлбөр намын
2024-2028 оны сонгуулийн
мөрийн хөтөлбөр**

Алсан хараа

Улс орны тусгаар тогтнол, эв нэгдлийг бататган "Хүнээ дээдэлсэн" хүн төвтэй төрийн тогтолцоог буй болгож, шударга, ардчилсан, аз жаргалтай, эрүүл нийгмийг төлөвшүүлж улс орноо хөгжүүлнэ.

1. Улс төрийн зорилт, хөтөлбөр

Зорилтын агуулга:

Монгол улсын эрхэм дээд баялаг бол Монгол хүн мөн. Монгол хүн төрийн хамгаалалтад байж хөгжлийн бодлогыг зорилго бүр Монгол хүний сайн сайхан байдлыг дээшлүүлж эрүүл байлган урт наслуулахад чиглэх болно.

Ардын уламжлалт ахуй соёл, сэтгэхүй, оюун санааны өвийг дээдлэн хөгжүүлж иргэн бүр ажил, сургууль, орлоготой байж ядуу иргэнгүй, нийгмийн чинээлэг дундаж давхарагатай, эдийн засгийн эрх чөлөө, хувийн хэвшил, өмчийн халдашгүй дархан байх эрхийг хуулиар чанд сахин хамгаалсан иргэний ардчилсан шударга төр нь улс орон, ард түмнийхээ эрх ашгийг дээдэлсэн Монгол орны оршин тогтнох, хөгжин цэцэглэх, сэрэн мандахыг үндэс болно.

1.1 Улс төрийн намууд төрд ноёрхох, ард иргэдээ намын харъяалал, нутаг ус, итгэл үнэмшил, сүсэг бишрэл, өмч хөрөнгөөр нь алагчлан зааглаж, хуваан өмчлөх үзэгдлийг эцэс болгож, нийгмийн талцал, хуваагдлын үндэс болсон улс төрийн намын хатуу гишүүнчлэлээс татгалзах;

1.2 Улс төрийн намууд төрийн өндөр албан тушаалд дэвшүүлж сонгосон, томилуулсан хүнийхээ төлөө хүлээх хариуцлагыг чангатгаж, төрийн албан хаагчид хээл хахууль авилгалын хэрэг үйлдсэн тохиолдолд хүлээх ял шийтгэлийг хүндрүүлж, төрийн албанд ажиллах эрхийг нь хязгаарлах;

- 1.3 Ард иргэдийг талцалд хүргэсэн нийгмийн амьдралын гол зангилаа асуудлууд түүний дотор Үндсэн хуулиар бүх ард түмний мэдэлд байхаар заасан асуудлыг ард түмний санал асуулгаар шийдэх ёсыг хэрэгжүүлж дэвшүүлэх ;
- 1.4 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор улс төрийн намууд бүх шатны сонгуульд нэр дэвших эмэгтэйчүүдийн квотыг 40%-иар тогтоох, төрийн албаны удирдах ажилтны 35-40%-ийг эмэгтэй нэр дэвшигчдээс сонгож байх;
- 1.5 Нүүдлийн соёл иргэншлийн үндсийн үндэс болсон малчин, мал, бэлчээрийн газар нутгийн дархлааг хангасан хууль эрх зүйн тогтвортой орчинг бий болгох;

2. Эдийн засгийн хөгжлийн зорилт, хөтөлбөр

Үндэснийхээ эдийн засгийн тусгаар тогтнолыг тууштай сахин бэхжүүлж, өргөн уудам нутаг дэвсгэр, эрчим хүч, түүхий эдийн нөөцөө түшиглэн инновацийн хүч, орчин үеийн тэргүүний техник технологийг ашиглаж өндөр үр ашигтай, тогтвортой, өөрийн хуримтлалаар өсөж хөгжих, өөрийгөө нөхөн тэтгэх, гадаад орчны өөрчлөлтөнд дасан зохицох чавдартай макро түвшний эдийн засгийн нэгдсэн орон зайг бий болгоно.

2.1 Төрийн бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөж, шинжлэн судлаж хэрэгжүүлдэг байх. Үүний тулд улс орны хөгжлийг төлөвлөх чадавхитай бодлого төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх. Үндэсний эдийн засгийн бодлого, хэтийн төлөвийг тодорхойлох, төсөөлөхдөө дараахь зарчмуудыг баримтлах

- Хүний хөгжил
- Эв зохицолтой хөгжил
- Тэнцвэртэй хөгжил
- Ногоон хөгжил
- Хуримтлалтай хөгжил
- Хөрш орнуудтай хорших хөгжил

2.2 Эдийн засгийн эрх зүйн орчинг бүхэл цогцоор дараахь шаардлагуудад нийцүүлэн төгөлдөржүүлэн хэрэгжүүлэх, бүтцийг шинэчлэх,



- Эдийн засгийн уналтыг зогсоох, тогтворжуулах, өсөлтийг хангах цогц бодлого хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтийн жилийн дундаж хурдацыг 6-7% байлгах;
- Олон улсын стандартад нийцсэн өндөр хөгжил бүхий банк, санхүү, даатгал, хөрөнгө оруулалт сан, хөрөнгийн зах зээлийн үйлчилгээний тогтолцоог эрчимтэй хөгжүүлж хууль эрх зүйн орчинг нь улам нээлттэй, ил тод хяналт зохицуулалттай болгох;
- Эдийн засгийн чөлөөт бүсийг жинхэнэ утгаар нь бүрдүүлж газар нутгийг нь тэлж, эдийн засгийн чөлөөт бүсийн хуулийг сонгодог утгаар гаргаж хэрэгжүүлэх;
- Үндэсний эдийн засгийн тусгаар тогтнол, аюулгүй байдал, тогтвортой байдлыг хэрэгжүүлэх, Төрийн бодлогын нэгдмэл байдлыг хангаж, эдийн засгийг улс төрийн нам, фракц, нам дамнасан бүлэглэлийн "улс төрийн барьцаа"-наас салгах
- Төр, хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагааны тогтвортой орчинг бүрдүүлэх;
- Гадаадын хөрөнгө оруулагчдад тавих шаардлага, хамтарч ажиллах гэрээ хэлэцээрүүдэд үндсэн хууль бусад хуулийг чанд мөрдөж улс орныхоо эрх ашгийг тууштай хамгаалах чадавхи бүрдүүлэх;

2.3 Үндэсний эдийн засгийн бүтцийг нягтаруулж, түлш, шатахуун, эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, нүүрс-хими, нефть-хими, өнгөт болон хар төмөрлөг, тенхик тоног төхөөрөмжийн салбарт өндөр технологи бүхий бага, дунд оврын үйлдвэрүүдээр эх орны түүхий эдийг боловсруулахыг дэмжсэн бодлого явуулах;

- Эрчим хүч импортлогч орноос экспортлогч орон болох;
- Ногоон эрчим хүч буюу нар, салхины цахилгаан станцаар нийт эрчим хүчний хэрэглээний 5-10% -ийг хангах;
- Орон нутагт сум дундын хэрэглээг хангахуйц бага дунд оврын усан цахилгаан станц барих бодлогыг дэмжиж хэрэгжүүлэх;



- Олборлолт - Экспортын чиг хандлагатай уул уурхайн салбарыг Олборлолт - Боловсруулалт - Экспортын чиг хандлагатай болгон өөрчлөх;
- Эх орныхоо эрдэс түүхий эдийн баялагыг ариг гамтай, байгаль экологид хор хөнөөл учруулахгүйгээр олборлож, хамгийн үр ашигтай, хөрөнгө оруулалттаа богино хугацаанд нөхөж, үр өгөөжөө өгөх технологийн шатанд хүртэл боловсруулж, дотоод хэрэгцээгээ бүрэн хангаж, экспортын тогтвортой нөөц, эх үүсвэр бүрдүүлэх;
- Санхүүжүүлэх олон улсын банк, санхүүгийн байгууллага, гадаадын хөрөнгө оруулагчаа олсон нөхцөлд дундаж хүчин чадалтай өнгөт болон хар төмөрлөгийн үйлдвэр, ховор металын үйлдвэр, химийн үйлдвэр, нефть боловсруулах үйлдвэр барихад зориулан төсөл хэрэгжүүлэх төр, хувийн хэвшлийн байгууллагуудад 10-15 жилийн хугацаатай баталгааг төрөөс гаргах механизмыг боловсруулж хэрэгжүүлэх;

2.4 Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлээр ард иргэдийнхээ хүнсний хэрэгцээг генийн өөрчлөлтгүй, экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, экспортлох хэмжээнд хүртэл тэтгэн хөгжүүлж, малчид, тариаланчдыг үнийн хэт алдагдалтай өөрчлөлт, зээлийн өрийн дарамтаас хамгаалах бодлого хэрэгжүүлэх;

- Мал аж ахуй, газар тариалан, хүсний ногооны бүтээгдэхүүнийг хамгийн өндөр технологиор иж бүрэн боловсруулах, дэлхийн стандартад нийцсэн экспортод гаргах чадамжийг бий болгож харилцан уялдаатай жижиг дунд үйлдвэрийг Баруун, Зүүн, Төвийн бүс болон төвийн бүсийн өмнөд дэд бүсэд байгуулах;
- Хүн ардынхаа хүнс тэжээлийн хэрэгцээг генийн өөрчлөлтгүй экологийн цэвэр бүтээгдэхүүнээр найдвартай хангаж, уламжлалт болон эрчимжсэн технологийг оновчтой хослуулан газар тариалан, жимс ногоо боловсруулах Хөдөө аж ахуй - аж үйлдвэрийн цогцолборыг Дархан-Уул, Дорнод, Сэлэнгэ, Увс, Төв аймгуудад байгуулах;
- “ Хашаандаа сайхан амьдарна ” уриан дор аймаг сумын төв, хот суурин газрын гэр хороололд өрхийн бичил үйлдвэрлэл хөгжүүлэх;

2.5 Улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийн хэрэгцээг бүрэн дүүрэн хангаж, дотоод зах зээлээ эзлэх хүчин чадал, технологи бүхий байгалын баялагт түшиглэлсэн, класик үйлдвэрлэлийг хөгжүүлэнэ,

2.6 Байгалын нөөц баялагийг түшиглэсэн боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэнэ.

3.Нийгмийн хөгжлийн зорилт хөтөлбөр

2.

3.1 "Хүн" төвтэй нийгмийн хөгжлийн бодлого баримталж, иргэдийнхээ амьдралын аюулгүй байдлын баталгааг бэхжүүлж, хүнээ хөгжүүлж, амьдралын баталгааг сайжруулж ядуурлыг бууруулж нийгмийн дундаж давхаргыг тэлэх,

- 2024-2028 онд цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийн доод хэмжээг үе шаттай нэмэгдүүлнэ.
- Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг тухайн жилийн инфляцийн жигнэсэн дундаж үзүүлэлтээр жилд нэг удаа индексжүүлж иргэдийн төлбөрийн чадварыг инфляцаас хамгаална.

3.2 Боловсролын салбарын бүх шатны сургалтын хөтөлбөрийг орчин цагийн шинжлэх ухааны боловсрол олгох шаардлагад нийцүүлэн сайжруулж Монгол бичиг, кирилл бичиг эзэмших "Хос бичигтэн", гадаад хэл эзэмших " Хос хэлтэн" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

- Хүүхэд, залуучуудын эх хэлний мэдлэгийг сайжруулах шаардлагын үүднээс 2025 оноос эхлэн их дээд сургуулийн элсэлтийн шалгалтын онооны 25 хувийг Монгол бичиг, Монгол хэлний найруулга, зөв бичих дүрмийн хичээлээр тооцож байх журамд шилжих;
- 2025 оноос эхлэн төрийн албанд ажиллах ажилтнуудаас Монгол бичгийн шалгалт авдаг болох. Төрийн албанд тэнцэх босго оноог 90 болгох;
- 2025 оноос Монгол бичгийг төрийн албаны ёсны бичиг болгох;
- Үндэсний их дээд сургуулиудын сургалтын стандартыг олон улсын хүлээн зөвшөөрөх түвшинд тогтоох, сургалт, сорилт-туршилтын лаборатори судалгаа шинжилгээний баазтай байх шаардлагыг үндэсний стандарт болгон мөрдүүлэх;



- Мэргэжилтэй ажилчин бэлтгэх шаардлагын дагуу орчин үеийн техник тоног төхөөрөмж материаллаг баазаар хангагдсан жишиг техник мэргэжлийн сургуулиудыг Ховд, Архангай, Өмнөговь, Дорнод, Дархан-Уул аймгуудад байгуулах;
- Шинжлэх ухаан, инновацийн салбарын санхүүжилтыг улсын төсвийн хөрөнгийн 1,5 хувьтай тэнцэх хэмжээнд тогтоож Шинжлэх Ухааны Академийн дэргэд үндэсний инновацийн төв байгуулах;

3.3 Эмнэлгийн үйлчилгээг цогцоор хөгжүүлж юуны өмнө, түгээмэл тархаж, иргэдийн эрүүл мэнд амь насанд ноцтой аюул учруулж буй өвчнийг дэлхийн түвшинд оношлох, эмчлэх үндэсний төвүүдийг төрөлжүүлэн бэхжүүлж, дэмжих;

- Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад алдаа гаргасан эмч, эмнэлгийн ажилтанд 8 хүртэл жилээр шоронд хорих ял, 20-80 сая төгрөгийн торгууль ноогдуулах хэт хатуурхсан заалт оруулсан нь эмч нар амиа аргацаах, хэрэгт орохгүй байх төдий үйлчилгээ үзүүлдэг "хамгаалалтын анагаах ухаан" хөгжих үндэс суурийг тавьсан байна. Иймд дээрхи хуулийн заалтыг хүчингүй болгож эрүүл мэндийн салбарын дотоод хариуцлагын тогтолцоо, шат дараалсан хяналт шалгалтыг эрс сайжруулах.
- Хувийн эмнэлгүүдийн тусгай зөвшөөрлийг 6 сараар сунгаж, байнгын дарамт шахалтанд байлгадаг гаж, хүнд сурталтай хяналтын тогтолцоог өөрчилж тусгай зөвшөөрлийг 2 жилээр сунгадаг тогтолцоонд шилжих;
- Улаанбаатар хотод түргэн тусламжийн төвүүдийн тоог нэмэгдүүлж 5-10 минутын дотор дуудлага очих хэмжээнд түргэн тусламжийн машины тоог нэмэгдүүлэх;

3.4 Монгол соёл иргэншлийн дэвшилтэт ололт, үнэт зүйлсийг уламжлал шинэчлэлийн ухаалаг зөв харьцаанд хадгалан, хамгаалах хөгжүүлэх замаар дэлхийн соёл урлагт үндэснийхээ соёлын эзлэх байр суурийг бэхжүүлэн, Монгол хэл, соёл мөхөж доройтох, өөр үндэсний хэл, соёлд уусан замхарах, өв уламжлал, ёс заншил алдагдах, оюун санааны амьдрал ядууран доройтохоос сэрэмжлэхэд соёл урлагийн бодлогын зорилт чиглэгдэнэ.

- Үндэсний язгуур урлаг, уртын дуу, сонгодог урлагийн үндсэн төрлүүд болох. Сонгодог хөгжим, бүжгэн жүжиг, дуурь, уран зураг, баримлын урлагийг төрөөс дэмжиж ивээлдээ авах;

- Урлагийн гоц авъяастай хүүхдүүд, багш нарыг гадаадын алдартай сургуулиудад сургаж бэлтгэдэг байсан уламжлалыг сэргээж хөгжмийн консерватори байгуулах;

3.5 Их спорт, нийтийн биеийн тамирыг харилцан уялдаатай хөгжүүлж, Олимпийн наадамд тамирчидаа бэлтгэх асуудал төрийн анхааралд байлгана;

- Олимпийн бэлтгэлийн үндэсний төв цогцолборыг байгуулна;
- Олимпийн төрлүүдээр үндэсний 1 ба 2 дугаар шигшээ баг, залуучуудын шигшээ баг байгуулж цалин хөлсийн төсвөөс санхүүжүүлнэ;
- Багш дасгалжуулагчдын ялангуяа анхны багш, бэлтгэл хангагчдын үнэлэмжийг дээшлүүлнэ;

4. Байгаль орчин хамгаалах зорилт, хөтөлбөр

Үндсэн бодлого чиглэл:

- ✓ Байгалийн нөөцийг үр өгөөжтэй ашиглан, эко системийн тогтвортой байдлыг хадгалах замаар хүртээмжтэй өсөлтийг бий болгон хүний хөгжлийн индексийг дээшлүүлэх тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлнэ.
- ✓ Цөлжилтийн эсрэг “Ногоон говь” олон улсын хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.
- ✓ “Усны нөөцийн нэгдсэн менежмент”-ийг шинэчлэн боловсруулж хүн ам, үйлдвэрлэлийн усны зохистой хэрэгцээг бодлогоор тодорхойлон үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- ✓ Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлэн ариун цэврийн байгууламжийг төрийн бодлогын салшгүй хэсэг болгон хуульчилж эрх зүйн орчинг баталгаажуулна.
- ✓ Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг хувийг тусгай хамгаалалтад авч, Хэрлэн, Орхон, Сэлэнгэ зэрэг томоохон голуудыг түшиглэн усны нөөцийн цогцолбор төслүүдийг хэрэгжүүлнэ.
- ✓ Цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрэн цахимжуулна.

4.1 Байгаль орчноо хамгаалан тэтгэж, хүрээлэн буй орчныг эрүүлжүүлэх бодлогыг шинэ шатанд гаргана.

- Улаанбаатар хот болон төв суурин газруудыг агаар, хөрс, усны бохирдлоос цэвэрлэх цогц хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Говь, талын бүс нутагт ундны усыг аж ахуйн зориулалтаар хэрэглэхийг багасгахад хүчтэй түлхэц өгөх эдийн засаг, эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- Улаанбаатар хот, бусад томоохон хот суурин газруудын цэвэрлэх байгууламж, хог хаягдлыг устгах, боловсруулах технологи, хүчин чадлыг олон улсын шилдэг жишигт хүргэж, хяналтыг тогтмолжуулна.
- Аж ахуйн хэрэгцээний таримал ойн талбайнуудыг үүсгэн хөгжүүлнэ.
- Цөлжилт эрчимтэй явж буй нутгуудад мал сүргийн бүтэц, маллагааны технологийг экологийн дарамт хамгийн бага байх шаардлагад нийцүүлэн зохицуулна.
- Ховордсон ан амьтан, ургамлыг уугуул нутагт нь буцаан үржүүлэх цогц арга хэмжээ авч, уул усыг нь дархлаажуулна.

4.2 Байгаль орчны нөхөн сэргээлт хийгээгүй аж ахуйн нэгжүүдийг хар жагсаалтанд оруулж, уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх эрхийг нь тодорхой хугацаагаар хязгаарлаж, дахин шинээр хайгуулын болоод ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй байна.

4.3 Газар түүний доорхи баялаг ард түмний өмч гэсэн Үндсэн хуулийн заалтын хэрэгжилтэнд хяналт тавих зорилгоор “Газрын тооллого” явуулах, Үүнд:

- Бэлчээрийн газар
- Дархан цаазат газар
- Тусгай хамгаалалттай газар
- Хувьчлагдсан газар
- Түрээсийн гэрээтэй газар
- Эзэмшүүлэх гэрээтэй газар, баялаг
- Ашиглуулах гэрээтэй газар, баялаг
- Хайгуулын гэрээтэй газар, баялаг
- Гадаадын хөрөнгө оруулагчид, Олон Улсын банк санхүүгийн байгууллага, Гадаадын хөрөнгийн биржүүд дээр барьцаалагдсан газар, баялаг



- Дотоодын банк санхүүгийн байгууллага, компани, хувь хүнд барьцаалагдсан газар, баялаг

4.4 Аялал жуулчлалын салбарт үндэсний онцлогт тулгуурласан хөтөлбөрүүдийг боловсруулж олон улсын стандартыг төлөвшүүлэхэд хууль эрх зүйн орчины шинэтгэл хийнэ.

- 4.4.1 Монголчуудын үүсэл гарвалын өлгий нутаг Орхоны хөндийг байгаль орчин, соёл, түүхийн өвийг төрийн хамгаалалтад авч, ногоон хөгжил, аялал жуулчлалын салбарын хөгжлийн тулгуур хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.
- 4.4.2 Байгалийн унаган байдлыг хадгалах замаар тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 4.4.3 Монгол Улсын төрөөс аялал жуулчлалын талаар баримтлах бодлого үзэл баримтлалд Монгол улсын нүүдлийн соёл иргэншлийг шингээсэн 4 улирлын өнгө төрх үзэсгэлэнт түүх соёлын дурсгалт газар, археологийн олдвор, дэлхийд нэн ховордсон биологийн олон төрөл зүйл зэрэг давуу талуудыг зүй зохистой хослуулсан, гадаад дотоодын жуулчдын эрэлт хэрэгцээ сонирхолд нийцсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх.
- 4.4.4 Гадаад дотоодын аялал жуулчлалыг нутгийн иргэдийн шууд оролцоонд тулгуурласан экологийн баримжаатай үзэл баримтлалыг Монгол улсын төрөөс аялал жуулчлалын талаар баримтлах бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлнэ.

5. Аюулгүй байдал, гадаад харилцааны зорилт, хөтөлбөр

5.1 Монгол Улсын гадаад бодлогын энхтайван, эв найрамдал, түншлэлийг эрхэмлэсэн уламжлалыг улам гүнзгийрүүлэн хөгжүүлнэ:

- Гадаад орнуудтай түншлэн хамтран ажиллах бүх хүрээнд үндэснийхээ эрх ашгийг найдвартай хамгаалан ул суурьтай хандах зарчмыг тууштай баримталж, нэгэнт харилцан тохиролцсон хүрээндээ найдвартай,



хариуцлагатай түнш байх баталгаа бүрдүүлэх эрх зүй, зохион байгуулалтын нөхцөл бий болгоно.

- Хил залгаа хоёр хөрш оронтой харилцаа, хамтын ажиллагаагаа цаашид өргөтгөн хөгжүүлэхэд онцгой ач холбогдол өгч, хөрш тус бүртэйгээ харилцан ашигтай, тэгш хэмтэй, тэнцвэртэй, хөгжил дэвшилд чиглэсэн тогтвортой худалдаа, хамтын ажиллагаа эрхлэх чиглэл баримтална.

5.2 Гадаадын хөрөнгө оруулагчидтай гэрээ хэлцэл хийхдээ Монгол Улсын тухайн үеийн хууль тогтоомжийг зөрчсөн бүх үйлдлүүдийг нэн анхааралтай шинжлэн үнэлж, улс үндэснийхээ эрх ашгийг хохироосон актуудыг хүчингүй болгох буюу өөрчлөх, Монголын талаас ийм үйлдэл хийсэн хүмүүст хуулийн хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авна.

5.3 Улс орныхоо гадаад, дотоод орчин нөхцлийг бодитой үнэлж, даяаршлын үед үндэснийхээ язгуур эрх ашгийг баталгаажуулан хамгаалахад чиглэсэн батлан хамгаалах бодлогоо хадгалан уламжлуулна.

- Насанд хүрсэн бүх эрэгтэйчүүд, цэргийн боловсрол олж, 18-45 насны эрчүүд 5 жил тутам улирлын цугларалтаар бэлтгэлээ сэргээх тогтолцоотой болох;
 - Хилийн хамгаалалтыг мэргэжлийн цэрэг болон нутгийн иргэдийн хамтын ажиллагаанд тулгуурлан баталгах,
 - Богино хугацаанд шилжин байрлаж, үүрэг даалгавар биелүүлэх чадвартай, мэргэжлийн десантын цэрэгтэй болох;
- Олон улсын энхийг сахиулах хүчний үйл ажиллагаанд оролцох мэргэшсэн цэрэг, офицеруудыг бэлтгэх тогтолцоог цаашид боловсронгуй болгон хөгжүүлэх;

МОНГОЛ УЛС ЦЭЦЭГЛЭН ХӨГЖИЖ, МОНГОЛ ХҮН БҮР ЭРҮҮЛ ЭНХ, ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ, АЗ ЖАРГАЛТАЙ АМЬДРАХ БОЛТУГАЙ.

---оо00оо---





**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.08.05 № 01/762
танай 2024.06.24-ны № 6/43 -т

ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ ХҮНИЙ ТӨЛӨӨ
НАМЫН ДАРГА Х.БАТ-ЯЛАЛТ ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аймагийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох "Монгол хүний төлөө" намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

"Монгол хүний төлөө" намын Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Монгол хүний төлөө" намын мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Төв аймгийн Сонгуулийн хороонд

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

019021080



**2024 ОНЫ
АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



1. МОНГОЛЫН ХҮНИЙ ТӨЛӨӨ НАМЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Монголын Хүний Төлөө Нам нь Монгол Улсдаа хүнлэг энэрэнгүй, хүн төвтэй, иргэний эрх зүйт нийгмийг цогцлоож, хууль ёсыг дээдлэн, хөгжил дэвшилд манлайлж, иргэний хяналт бүхий төрийн тогтолцоог байгуулах эрхэм зорилгыг баримтална.

Иргэний хяналтын тогтолцоо нь төрийн албан хаагчдын сахилга бат, ёс зүй, төрийн болон нийтийн хөрөнгөний зарцуулалт, хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих арга, замаар хэрэгжинэ. Түүнчлэн,

Бид:

1-рт: Монгол Улсын үлэмж баялаг нь хүн **Та** хэмээн дээдэлнэ;

2-рт: Аливаа бодлогыг эрүүл агаар, эрүүл хүнс, эрүүл орчин, эрүүл эрх зүй, эрүүл нийгмийн шаардлаганд нийцүүлэн хэрэгжүүлнэ;

3-рт: Тулгар төрийг хүчирхэг, хяналттай, тогтвортой, алсын хараатай, хэтийн бодлогоор цогцлоон байгуулж, Монгол төрийн бахархалыг бүрдүүлнэ;

4-рт: Нийтийн эрх ашгаар хувийн эрх ашгийг хязгаарлаж, нийгмийн баялгийг шударга хуваарилан, олигархи бүлэглэлийн эрх мэдэл, хөрөнгө мөнгөний шунал тачаалыг хязгаарлан зогсоож, хөдөлмөрөө шударгаар үнэлүүлдэг бүтээлч, үйлдвэрлэгч үндэсний дундаж давхаргыг хүчирхэгжүүлнэ;

5-рт: Хүчтэй нь хүчгүйгээ захирдаг адгуусны хуулийг халж, соёлт нийгмийг оюун ухаан, амьдралын туршлагаараа залж удирдах, хөдөлмөр чадвараараа манлайлах, мэдлэг, боловсролоо дээдэлсэн, ёс зүйтэй, оюунлаг, нийгмийг цогцлоон байгуулна;

6-рт: Хууль цаазын өмнө хэн боловч тэгш эрхтэй байх зарчмыг хангах үүрэгтэй шүүхийн байгууллагыг шударга, тэнцвэртэй байлгах зорилгоор төр болон ард түмэн нь эрх мэдлээ хамтран хэрэгжүүлдэг шүүх байгууллагын сонгодог хувилбарыг нэвтрүүлж хэрэгжүүлнэ;

7-рт: Гадаадын аливаа этгээдтэй эрх тэгш, нөхөрсөг харилцааг баримтлах хэдий ч Монгол Улсад Монгол хүний зүй ёсны эрх ашгийг дээдлэн эрхэмлэнэ;

8-рт: Ард олны эв нэгдлийг бэхжүүлэн, Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгана;

9-рт: Өвөг дээдсээс уламжлан ирсэн газар нутаг, их түүх, уламжлалт соёл, байгалийн баялгаа хайрлан дээдэлж, эх орны баялаг, түүхий эдийг боловсруулан, баяжуулах үйлдвэрлэлийн бодлогыг хөхиүлэн хөгжүүлнэ;

хэмээн дурдваас,

Өнө эртний өвөг дээдсийн сургаалыг санаж, ташаарсан

алдааг нь давталгүй сургамж хэмээн үзэж, нүүдэлчин удмын суу ухааныг биширч, өнөө цагийн эрдэмтэн судлаачдаа өргөн дээдэлж, Мөнх Хөх Тэнгэрийн ивээл дор **МОНГОЛЫН ХҮНИЙ ТӨЛӨӨ НАМ**-ыг үүсгэн байгуулж, даяар улс

олноо зарлан тунхаглав.

УЛААНБААТАР ХОТ

2017 оны 2-р сарын 17-ны өдөр



2

3.1.3. ЭМД-н оновчтой, үр дүнтэй, энэрэнгүй хувилбарыг боловсруулж нэвтрүүлнэ.

3.2. Хүн амын өсөлт

3.2.1. Хүн амын өсөлт нь улсын хөгжлийн чухал хэсэг бөгөөд эдийн засгийн эрчимтэй өсөлтийн гол үзүүлэлт гэж үзнэ.

3.2.2. Улсын орны эдийн засгийн чадавхи сайжирч, иргэдийн ирээдүйдээ итгэх итгэл нэмэгдэх нь хүн амын өсөлтөнд сайнаар нөлөөлөх тул урамшууллын оновчтой бодлого нэвтрүүлнэ.

3.3. Ажилгүйдлийг бууруулах бодлого

3.3.1. Ажлын байрыг нэмэгдүүлэх бүхий л боломжийг эрэлхийлж ашиглана /хүүхэд хүмүүжүүлэн, саатуулж, сургадаг цэцэрлэг, сургууль, өдөр өнжүүлэх нь хүүхдийн эцэг эхэд ажил хийх чөлөө зав олгох үүрэгтэй юм/.

3.3.2. Ажлын байр олноор бий болгож, төсвийн ачааллыг багасгадаг жижиг дунд аж ахуйнуудыг татварын хөнгөлөлт, санхүүгийн урамшуулал, дэмжлэгийг нэмэгдүүлэх эрхзүйн орчныг бүрдүүлнэ.

3.3.3. Боловсролын бодлого, мэргэжлийн сургалт, зээлийн бодлого зэрэг нь ажилгүйдлийг багасгахад чиглэгдэх бодлого, зорилгыг хэрэгжүүлэх эрхзүйг таатай орчныг бүрдүүлэхийг төлөө ажиллана.

3.4. Нийгмийн халамж

3.4.1. Нийгмийн халамж нь зорилтот бүлэгтээ чиглэж, хүрч байх бүртгэл тооцооны тогтолцоог бүрдүүлнэ. Халамжийн хавтгайрсан бодлогоос зайлсхийж, бэлэнчлэх сэтгэлгээг багасгана.

3.4.2. Бие дааж амьдрах болон хөдөлмөрлөх чадвар нь хязгаарлагдмал иргэдийг айх аюулгүй, санаа амар амьдрах нийгмийн тогтолцоог хэрэгжүүлнэ.

4. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БОДЛОГО

4.1. Ерөнхий боловсрол

4.1.1. Боловсролын салбар онцгой салбар, онцгой хандлага, бодлого шаардлагатай суурь салбар. Он цагийн хэлхээсээр харвал ирээдүйг бүтээгч салбар, бид хэн байх, бид юунд бэлэн байх, бид өрсөлдөх чадвартай эсэх, бид хөгжиж чадах эсэхийг тодорхойлох онцгой өвөрмөц салбар гэдгийг ухааран хандах болно.

4.1.2. Боловсролын салбарыг онцгойлон анхаарах бодлого хэрэгжүүлнэ. Ирээдүйд улс орны хөгжлийг тодорхойлох иргэдийг хүмүүжүүлэх, монголчууд юунд бэлдэх, дэлхийн түвшинд өрсөлдөх чадвартай болгох, цаашдын эрчимтэй хөгжлийг тодорхойлогч салбар хэмээн үзнэ.

4.1.3. Боловсролын тогтолцоог тогтвортой, байнга хөгждөг байдлаар зохион байгуулна. Үндэсний эрдэмтэн мэргэд, багш сурган хүмүүжүүлэгч нарын хүчээр үндэсний онцлогийг харгалзсан боловсролын хөтөлбөрийг боловсруулна. Боловсролын хөтөлбөр нь сургуулийн өмнөх, бага, дунд, ахлах сургуулийн боловсрол, мэргэжлийн, тусгай, дээд боловсролын зэрэг бүх салбар шатлалыг хамарсан шинжлэх ухаанч, цогц бодлого байна.

4.1.4. Боловсролын салбарын хөгжлийн хөшүүрэг нь багш, сурган хүмүүжүүлэгчдийн хөдөлмөрийн үнэлгээ бөгөөд багш, сургагчдын нийгмийн баталгааг сайжруулснаар тэдний нэр хүнд, боловсрол, мэдлэг дээшилж, боловсролтой, соёлтой **МОНГОЛ ХҮН** бэлтгэх тогтолцоо бүрэлдэнэ.



- 5.1.2. Үндэсний мөнгөн тэмдэгтийг долларын түрэмгий нөлөөнөөс хамгаалах, гадаад худалдааны орлого үндэсний банкаар дамждаг тогтолцоог бий болгож хэрэгжүүлнэ.
- 5.1.3. Төсвийн бодлого нь улсын төсөв бүрдүүлэхийн зэрэгцээ дотоодын зах зээл, хүнсний аюулгүй байдлыг давхар хамгаалж байх бодлогыг баримтална.
- 5.1.4. Банк санхүүгийн тогтолцоог эрүүл, ёс зүйтэй шударга болгож, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн таатай нөхцөл бүрдүүлэх чиглэлд ажиллана.
- 5.1.5. Эдийн засаг, үйлдвэрлэлийг дэмжих гаалийн, онцгой, ашгийн татварын зохистой бодлого явуулна.
- 5.1.6. Жижиг аж ахуйн нэгжүүд татвар төлж, төсөв бүрдүүлэхээс гадна ажлын байр олноор бий болгодог онцлогийг харгалзаж дэмжлэг үзүүлнэ.

5.2. Хөдөө аж ахуй

- 5.2.1. Хөдөө аж ахуй, мал аж ахуй, газар тариалан нь улсын хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүн ардын эрүүл, урт наслалтын үндэс гэж үзнэ.
- 5.2.2. Монгол улсын өсөж, үрждэг баялаг болох мал сүргийг үр дүнтэй, зөв зохистой хөгжүүлснээр өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх бөгөөд орон нутагт ажлын байр бий болгох, төсвийн орлогыг нэмэгдүүлэх эх үүсвэр хэмээн үзэж дэмжиж ажиллана.
- 5.2.3. Нүүдлийн мал аж ахуй нь эрчимжүүлсэн мал аж ахуйтай зэрэгцэн хөгжиж, давуу талаа илэрхийлэн өрсөлдөх ёстой уламжлалт суурь салбар мөн гэж үзнэ.
- 5.2.4. Мал эмнэлэгийн нэгдсэн бодлого, нэгдсэн мэдээлэл, нэгдсэн хяналт, нэгдсэн хангалт, нэгдсэн сүлжээгээр мал сүргийг эрүүл байлгаж дотоодын болон экспортын чанар шаардлага хангана.
- 5.2.5. Малчин-үйлдвэрлэгч-борлуулагч гэсэн хамтарсан хэлбэрээр ажиллах хоршооллын бодлогыг дэмжинэ.

5.3. Газар тариалан

- 5.3.1. Тариалангийн аж ахуй нь улсын хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүн ардын эрүүл, урт наслалтын үндэс гэж үзнэ.
- 5.3.2. Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.

5.4. Аж үйлдвэр

- 5.4.1. Дэлхийн нийт хэрэглээний зах зээлийн 25%-ийг бүрдүүлдэг том гүрнүүдийн дунд оршдог давуу талаа ашиглан үйлдвэрлэгч, экспотлогч улс болох бүрэн боломжтой гэж үзнэ.
- 5.4.2. Дотоодын түүхий эдийн үйлдвэрлэл, боловсруулалтыг түлхүү дэмжинэ.
- 5.4.3. Байгальд хор хөнөөлгүй, технологийн дэвшилтэт үйлдвэрүүдэд дэмжлэг үзүүлнэ.

- 5.5. Худалдаачид нь нийгмийн эрчимтэй хөгжилд томоохон хувь нэмэр оруулдаг бөгөөд зах зээлийг соргогоор мэдэрч зохицуулах, судлах, үйлдвэрлэл хөгжүүлэх томоохон хүчин болохын хувьд үйл ажиллагааг нь дэмжиж, борлуулалтыг нэмэгдүүлэх бодлого баримтална.

5.6. Уул уурхай

- 5.6.1. Байгалийн бүх баялаг ард түмний өмч гэсэн Монгол улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалаар хариуцлагатай уул уурхайн хөгжлийг зохицуулна.



6.4.2. Хүний эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн хууль эрх зүйг сахиулдаг иргэний хяналтын тогтолцоог байгуулна.

6.5. Шүүх засаглал

6.5.1. Бүх шатны шүүгчид нь хараат бусаар, шударгаар ажиллах боломжтой шүүхийн тогтолцоог бий болгох хууль эрхзүйн орчинг бүрдүүлнэ.

6.5.2. Монгол улсын нэрийн өмнөөс төрийн төлөөлөл шүүгч, ард түмний төлөөлөл нар хамтран шийдвэр гаргадаг тогтолцоог сэргээнэ.

6.5.3. Шүүхийн байгууллагыг шударга, тэнцвэртэй байлгах зорилгоор төрийн төлөөлөл болох шүүгч нь ардын төлөөлөгчтэй хамтран, хараат бус, шударга шийдвэр гаргадаг байх эрхзүйн орчинг бүрдүүлнэ.

6.5.4. Хүн өөрийгөө болон бусдыг өмгөөлөх эрхийг чөлөөтэй болгож нээнэ.

6.6. Хүчний байгууллагын шинэчлэл

6.6.1. Хууль хяналтын байгууллагууд "Гүйцэтгэл – цагдаа, хяналт – прокурор, шийдвэр – шүүх" гэсэн схемийн дагуу хараат бус, шударгаар үйл ажиллагаа явуулдаг байх хууль эрхзүйн таатай орчинг бүрдүүлэхийн төлөө ажиллана.

7. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

7.1. Батлан хамгаалах

7.1.1. Хугацаат цэргийн алба нь батлан хамгаалахын үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ залуучуудыг эх оронч сэтгэлтэй, бие бялдар, хүмүүжлийн өв тэгш хөгжилтэй, хамтран ажиллах чадвартай, бүтээн байгуулах тэмүүлэлтэй болгох сургалт хүмүүжлийн оновчтой хөтөлбөр байхаар хэрэгжүүлнэ.

7.2. Гадаад харилцаа

7.2.1. Төвийг сахих, эвсэлд үл нэгдэх, цөмийн зэвсэггүй бүс байх уламжлалт бодлогоо баримтлахыг чухалчилна.

7.2.2. Дипломат харилцаа нь аюулгүй байдал, тусгаар тогтнолыг хангах, бүх салбар дахь харилцааг дэмжих, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой ажиллана.

7.2.3. Дэлхийн аль ч улсад Монгол улсын иргэний эрхийг хангах, хамгаалах бодлогыг баримтлана.

7.3. Гадаадын хөрөнгө оруулалт

7.3.1. Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж дэлхийн түвшинд дүйцүүлэх гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

7.3.2. Дотоодын зах зээлд хамгаалах шаардлагатай чухал салбарыг тодорхойлж, уг салбарт гадаадын хөрөнгө оруулагчдын хэт давамгайл байдлыг хязгаарлана.

7.4. Гадаад худалдаа

7.4.1. Мөнхийн 2 хөрштэйгээ харилцан ашигтай, оновчтой харилцаа, худалдааны бодлогыг баримталж харьцана.

7.4.2. Гадаад худалдааны гэрээ, бодлогоор дотоод үйлдвэрлэлээ хөгжүүлэх чиглэл, захиалга хийдэг тогтолцоог үүсгэнэ.

< ----- >
Я

